



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА
ЭРХЛЭГЧИЙН САЛБАРЫН 2025 ОНЫ III УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ

2025 ОН



САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН



САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУ, ҮНЭТ ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ
МЭДЭЭ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



ХЯНАЛТ ШАЛГАЛТ



СУРГАЛТ



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ДҮГНЭЛТ

Товчилсон үгийн тайлал

1. Хороо–Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ–Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
3. ХЭ–Хувьцаа эзэмшигч
4. ХНХ–Хувь нийлүүлсэн хөрөнгө
5. ХНХХ – Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1. Салбарт хэрэгжиж буй журмууд

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршил

Хүснэгт 3. Хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 4. Орлогын тайлангийн үзүүлэлт

Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн тоо

Зураг 2. Бүртгэл зөвшөөрлийн хүсэлт

Зураг 3. ҮМҮЧЭТХЭАЭ иргэд байршлаар

Зураг 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

Зураг 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Зураг 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Зураг 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Зураг 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Зураг 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ

Зураг 10. Худалдан авсан болон худалдсан үнэт эдлэлийн борлуулалт

Зураг 11. Худалдан авсан болон худалдсан алтан эдлэлийн борлуулалт

Зураг 12. Худалдан авсан болон худалдсан мөнгөн эдлэлийн борлуулалт

Зураг 13. “JUNWEXSAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд оролцсон зураг

Зураг 14. “Монгол дархны уламжлал, шинэчлэл” чуулган



ҮМҮЧЭТХЭАЭ-ИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖУУД

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.9. үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

Зөвшөөрлийн тухай хууль

8.1 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт

2.20. үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

Зөрчлийн тухай хууль

11.6 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээг хууль бусаар эрхлэх

1. Хадгаламж, зээл, төлбөр тооцооны, эсхүл хуульд заасны дагуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй явуулах санхүүгийн бусад үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр, эсхүл хууль бусаар явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.29 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих

11.30 дугаар зүйл. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль зөрчих

1.2. Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоосон, эсхүл төлбөр тооцоо гүйцэтгэсэн, эсхүл зарлан сурталчилсан бол тухайн үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд зөрчлөө арилгах талаар эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол тусгайлан олгосон эрхийг хасаж хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль



ҮМҮЧЭТХЭАЭ–ИЙН САЛБАРЫН ХОЛБОГДОХ ЖУРМУУД

Д/Д	Журмын нэр	Баталсан огноо	Тогтоолын дугаар
1	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам	2020.03.25	150
2	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам	2023.06.23	233
3	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам	2020.12.23	1048
4	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	2020.03.25	151
5	Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам	2020.04.08	179
6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам	2023.01.13	22

Хүснэгт 1. Салбарт хэрэгжиж буй журмууд

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 51 хуулийн этгээд, 495 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 2-оор буурч, иргэдийн тоо 35-аар өссөн үзүүлэлт юм.

2024.III



53



460

2025.III



51



495

Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Тайлант хугацаанд буюу 2025 оны III улиралд нэр бүхий 2 хуулийн этгээд, 25 иргэнээс дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.



2

Тусгай зөвшөөрөл



25

Тусгай зөвшөөрөл

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдээс ХНХХ, ХЭ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, салбар нээн ажиллуулах тухай, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх, хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх зэрэг нийт 7 хүсэлт ирүүлснийг хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.



1

ХНХХ, ХЭӨ



2

Салбар нээх



1

ЭБАТ



3

ХАЯГ

Зураг 2. Бүртгэл, зөвшөөрлийн хүсэлт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН БАЙРШИЛ, БҮС НУТАГ

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 72.9 хувь буюу 361 нь Улаанбаатар хотод, 27.1 хувь буюу 134 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдүүдийг байршлаар ангилан харуулбал:

Тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд	Үнэт металл болон үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд
Сүхбаатар	5	7	4	12
Хан-Уул	3	8	1	12
Баянзүрх	6	7	8	3
Чингэлтэй	71	164	29	16
Баянгол	14	17	2	5
Сонгинохайрхан	5	9	1	2
Орон нутаг	55	7	72	1

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил


Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн 64.4 хувь буюу 87 иргэн Баянхонгор, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 35.6 хувь буюу 47 иргэн бусад аймгуудад үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн тусгай зөвшөөрөлтэй 51 хуулийн этгээдээс 1 хуулийн этгээд орон нутагт буюу Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлж байна. Орон нутагт арилжаа эрхлэгч иргэдийн үйл ажиллагаа эрхэлж буй байршлын дэлгэрэнгүйг зураг 3-т үзүүлэв.



Зураг 3. Арилжаа эрхлэгчид байршлаар


ҮМҮЧЭТХЭАЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 51 хуулийн этгээд нь 81 хувьцаа эзэмшигчийн 6,334,506.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 3-аар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 37.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




Зураг 4. ХНХ-ийн хэмжээ (мянган төгрөг)

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн хувьцаа эзэмшигчдийн нийт ХНХ-ийн хэмжээ 6,334,506.1 мянган төгрөг байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай ҮМҮЧЭТХЭАЭ-ийн ХНХ-ийн нийт хэмжээ 816,000.0 мянган төгрөг буюу 12.8 хувийг эзэлж байна.




Зураг 5. Хөрөнгө оруулалтын бүтэц (мянган төгрөг)



Зураг 6. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ҮНЭТ МЕТАЛЛЫН БОРЛУУЛАЛТ

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 1,380 кг үнэт металлыг 293,817,501.7 мянган төгрөгөөр худалдан авч, 985 кг үнэт металлыг 312,136,322.2 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын үнийн дүн 1.1 дахин, худалдсан үнэт металлын үнийн дүн 1.2 дахин тус тус өссөн байна.




Зураг 7. Худалдан авсан болон худалдсан үнэт металлын хэмжээ

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 782.6 кг алтыг 290,084,228.9 мянган төгрөгөөр худалдан авч, 800.7 кг алтыг 305,973,251.5 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна.

Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтны үнийн дүн 1.1 дахин, худалдсан алтны үнийн дүн 1.2 дахин тус тус өссөн үзүүлэлт юм.

Өөрөөр хэлбэл худалдан авсан алтны хэмжээ 0.7 дахин буюу 24.7%, худалдсан алтны хэмжээ 0.8 дахин буюу 20.4%-иар тус тус буурсан байна.



Зураг 8. Худалдан авсан болон худалдсан алтны хэмжээ

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 354.2 кг мөнгийг 3,346,306.4 мянган төгрөгөөр худалдан авч, 183.7 кг мөнгийг 5,955,510.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна.


Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1 дахин, үнийн дүн 2.54 дахин өссөн бол худалдсан мөнгөний хэмжээ 1.61 дахин, үнийн дүн 5.59 дахин өссөн үзүүлэлт юм.



Зураг 9. Худалдан авсан болон худалдсан мөнгөний хэмжээ

ҮНЭТ ЭДЛЭЛИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ


Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 26,244,623.4 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 45,524,568.6 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт эдлэл болон худалдан борлуулсан үнэт эдлэлийн үнийн дүн тус тус 1.5 дахин өссөн үзүүлэлт юм.



Зураг 10. Худалдан авсан болон худалдсан үнэт эдлэлийн борлуулалт

Алтан эдлэлийн борлуулалт


Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 19,136,137.3 мянган төгрөгийн алтан эдлэл худалдан авсан бол 28,875,935.6 мянган төгрөгийн алтан эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан алтан эдлэлийн үнийн дүн 1.4 дахин, худалдан борлуулсан алтан эдлэлийн үнийн дүн 1.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 11. Худалдан авсан болон худалдсан алтан эдлэлийн борлуулалт

Мөнгөн эдлэлийн борлуулалт

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 5,860,970.4 мянган төгрөгийн мөнгөн эдлэл худалдан авсан бол 14,368,359.1 мянган төгрөгийн мөнгөн эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөн эдлэлийн үнийн дүн 1.7 дахин, худалдан борлуулсан мөнгөн эдлэлийн үнийн дүн 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 12. Худалдан авсан болон худалдсан мөнгөн эдлэлийн борлуулалт

Бусад үнэт эдлэлийн борлуулалт

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 1,247,515.7 мянган төгрөгийн бусад үнэт эдлэлийг худалдан авсан бол 2,280,273.8 мянган төгрөгийн бусад үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан болон худалдсан бусад үнэт эдлэлийн үнийн дүн тус тус 1.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


ҮЗҮҮЛЭЛТ	2024.III	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2025.III	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18,047,100.4	22.0	8,450,529.8	9.6
Дансны авлага	5,108,058.6	6.2	6,042,126.5	6.9
Татвар, НДШ – ийн авлага	490,140.5	0.6	866,678.1	1.0
Бусад авлага	2,715,508.3	3.3	4,135,374.8	4.7
Бусад санхүүгийн хөрөнгө	–	–	5,100.0	0.0
Бараа материал	33,945,666.5	41.4	39,441,080.7	44.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,622,779.7	8.1	15,335,877.3	17.5
Бусад эргэлтийн хөрөнгө	451,245.6	0.6	41,142.1	0.0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,756,445.2	2.1	1,550.0	0.0
Эргэлтийн хөрөнгийн дүн	69,136,944.9	84.3	74,319,459.4	84.6
Үндсэн хөрөнгө	11,489,331.7	14.0	12,099,491.4	13.8
Биет бус хөрөнгө	925,886.8	1.1	967,101.1	1.1
Урт хугацаат хөрөнгө оруулалт	407,374.1	0.5	408,604.1	0.5
Хойшлогдсон татварын хөрөнгө	36,884.0	0.2	71,225.1	0.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө	–	–	7,386.0	0.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,859,476.5	15.7	13,553,807.8	15.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	81,996,421.4	100.0	87,873,267.2	100
Дансны өглөг	18,296,382.6	22.3	16,917,269.8	19.3
Цалин, татвар, НДШ өглөг	2,575,276.6	3.1	3,297,395.0	3.8
Банкны богино хугацаат зээл	3,937,353.5	4.8	2,588,216.9	2.9
Хүүний өглөг	961,040.7	1.2	1,158,741.2	1.3
Ногдол ашгийн өглөг	–	–	1,319.9	0.0
Урьдчилж орсон орлого	3,448,636.6	4.2	8,077,797.4	9.2
Нөөц /өр төлбөр/	18,388.9	0.0	10,265.1	0.0
Бусад богино хугацаат өр төлбөр	7,760,590.3	20.9	6,156,225.2	7.0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	–	–	889,889.1	1.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	36,997,669.1	45.1	39,097,119.6	44.5
Урт хугацаат зээл	8,706,805.6	10.6	12,279,797.7	14.0
Хойшлогдсон татварын өр	5,050.0	0.0	53,757.9	0.1
Бусад урт хугацаат өр төлбөр	–	–	214,174.3	0.2
Урт хугацаат өр төлбөрийн дүн	8,711,855.6	10.6	12,547,729.9	14.3
Өр төлбөрийн нийт дүн	45,709,524.8	55.8	51,644,849.5	58.8
Өмч	10,063,429.0	12.3	6,334,506.1	7.2
– хувийн	10,063,429.0	12.3	6,334,506.1	7.2
Халаасны хувьцаа	–	–	–168,000.0	0.2
Нэмж төлөгдсөн капитал	2,278,232.0	2.8	2,278,232.0	2.6
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	713,396.0	0.9	713,396.1	0.8
Эздийн өмчийн бусад хэсэг	1,448,561.0	1.8	1,262,594.0	1.4
Хуримтлагдсан ашиг	21,783,278.5	26.6	25,807,689.5	29.4
Эздийн өмчийн дүн	36,286,896.6	44.3	36,228,417.7	41.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	81,996,421.4	100.0	87,873,267.2	100.0

Хүснэгт 3. Хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

ҮМҮЧЭТХЭАЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ


2024.III

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын нэгтгэлд тайлант хугацааны үзүүлэлтээр 53 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд 100 хувийн ирцтэйгээр хамрагдсан. Тайлант хугацаанд хуулийн этгээдүүд нь нийт 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 81,996,421.4 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.



2025.III

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын нэгтгэлд нийт 51 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд 100 хувийн ирцтэйгээр хамрагдлаа. Тайлант хугацаанд хуулийн этгээдүүд нийт 81 хувьцаа эзэмшигчийн 6,334,506.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 87,873,267.2 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.



Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн ХНХ, нийт хөрөнгө, хуримтлагдсан ашгийн нийт дүнд дараах байдлаар өөрчлөлт орсон байна.




ҮМҮЧЭТХЭАЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН БОРЛУУЛАЛТЫН НИЙТ ОРЛОГО, ЦЭВЭР АШИГ

2024.III	2025.III
Нийт орлого 54,365,874.8 мян.төг	Нийт орлого 62,637,971.4 мян.төг
Борлуулалтын орлого 52,719,126.9 мян.төг	Борлуулалтын орлого 61,800,746.4 мян.төг
Нийт зардал 44,464,684.2 мян.төг	Нийт зардал 53,021,981.8 мян.төг
Цэвэр ашиг 9,901,190.6 мян.төг	Цэвэр ашиг 9,615,989.6 мян.төг

- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 51 хуулийн этгээд нь 62,637,971.4 мянган төгрөгийн нийт орлоготой, 53,021,981.8 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 9,615,989.6 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 0.9 дахин буурсан үзүүлэлт юм.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 98.7 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.

ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт зардлын 16.2% буюу 8,574,084.7 мянган төгрөгийг ерөнхий ба удирдлагын зардал, 64.9% буюу 34,428,919.9 мянган төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, 12.7% буюу 6,714,297.9 мянган төгрөгийг борлуулалт, маркетингийн зардал эзэлж байгаа бол үлдсэн 6.2% буюу 3,304,679.3 мянган төгрөгийг бусад зардал эзэлж байна.



ҮМҮЧЭТХЭЭ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлтүүд	2024.III		2025.III	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Нийт орлого	54,365,874.8	100%	62,637,971.4	100%
Борлуулалтын орлого (цэвэр)	52,719,126.9	97%	61,800,746.4	98.7%
Бусад орлого	1,646,747.9	3%	837.225.0	1.3%
Нийт зардал	44,464,684.2	100%	53,021,981.8	100%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	30,203,614.2	67.9%	34,428,919.9	64.9%
Борлуулалт, маркетингийн зардал	5,724,086.6	12.9%	6,714,297.9	12.7%
Ерөнхий ба удирдлагын зардал	6,090,922.1	13.7%	8,574,084.7	16.2%
Санхүүгийн зардал	732,951.9	1.6%	1,532,892.6	2.9%
Бусад зардал	391,835.4	0.9%	546,735.1	1.0%
Татварын зардал	1,262,378.9	2.8%	1,124,396.4	2.3%
Тайлант үеийн цэвэр ашиг	9,901,190.6		9,615,989.6	

Хүснэгт 4. Орлогын тайлангийн үзүүлэлт

ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдээс давхардсан тоогоор нийт 161 санхүүгийн тайлан, 548 арилжааны мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулж, нийт 116 тайлангийн хариуг хүргүүлсэн. Үүнд:

46 ҮМҮЧЭТХЭАЭ
хуулийн этгээд



ЗӨВЛӨМЖ

38 ҮМҮЧЭТХЭАЭ
хуулийн этгээд



ТАЙЛАНГИЙН ХАРИУ

26 ҮМҮЧЭТХЭАЭ
хуулийн этгээд



ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

6 ҮМҮЧЭТХЭАЭ
хуулийн этгээд



ХҮЧИНГҮЙ БОЛГОХ МЭДЭГДЭЛ

116

Тайлант улиралд нэр бүхий 6 хуулийн этгээд, 3 иргэний үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны хурлаар хэлэлцэж хүчингүй болгосон.

6 ҮМҮЧЭТХЭАЭ
хуулийн этгээд



3 ҮМҮЧЭТХЭАЭ
иргэн



СУРГАЛТ

“Тайлагнал болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэл” сэдэвт сургалтыг ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтнуудад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Хорооны Өвөрхангай аймаг дахь орон нутгийн төлөөлөгчийн хүсэлтээр 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус аймагт үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд Хорооны 2020 оны 150 дугаар тогтоолоор баталсан журмын талаарх цахим сургалт зохион байгуулсан.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Татварын багц хуульд нэмэлт өөрчлөлт орохтой холбогдуулан үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар холбогдох саналыг хүргүүлсэн.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2025.05.28-ны өдрийн тушаалаар батлагдсан үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний стандартын төсөл хэлэлцэх, дүгнэлт гаргах зорилго бүхий Үнэт эдлэлийн стандартчиллын техникийн хорооны бүрэлдэхүүн хэсэгт Хорооны төлөөлөл ажиллаж, Стандарт, хэмжил зүйн газраас боловсруулсан MNS ISO 9202:2025, MNS ISO 11596:2025, MNS ISO 15093:2025 стандартуудын төсөлд Хорооны холбогдох саналыг тусгуулсан.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

- ✓ MNS ISO 9202:2025,
- ✓ MNS ISO 11596:2025,
- ✓ MNS ISO 15093:2025



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн салбарын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”-г хийх ажлын хүрээнд ҮМҮЧЭТХЭАЭ иргэн, хуулийн этгээдүүдээс Дэлхийн банкны аргачлалын дагуу холбогдох асуумжуудыг авч, фокус бүлгийн уулзалтуудыг хийсэн. Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын тушаалаар байгуулагдсан эрсдэлийн үнэлгээний ажлын хэсгийн гишүүдийг оролцуулсан эхний хэлэлцүүлгийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээний талаар хэлэлцэв.



WORLD BANK GROUP

ОХУ-ын Санкт Петербург хотод 2025.02.05–2025.02.09 өдрүүдэд зохион байгуулагдсан олон улсын эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн “JUNWEXSAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд Хорооны төлөөлөл оролцож, салбарын талаар мэдээлэл солилцож, туршлага судлав.



Зураг 13. “JUNWEXSAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд оролцсон зураг

МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор “Түмэн Эрдэнэс” ГҮТББ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран “Монгол дархны уламжлал, шинэчлэл” анхдугаар чуулганыг зохион байгуулав.



Зураг 14. “Монгол дархны уламжлал, шинэчлэл”


Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 51 хуулийн этгээд, 495 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 2–оор буурч, иргэдийн тоо 35–аар өссөн үзүүлэлт юм.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн хувьцаа эзэмшигчдийн нийт ХНХ–ийн хэмжээ 6,334,506.1 мянган төгрөг байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай ҮМҮЧЭТХЭАЭ–ийн ХНХ–ийн нийт хэмжээ 816,000.0 мянган төгрөг буюу 12.8 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ эрхлэгчид 1,380 кг үнэт металлыг 293,817,501.7 мянган төгрөгөөр худалдан авч, 985 кг үнэт металлыг 312,136,322.2 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан үнэт металлын үнийн дүн 1.1 дахин, худалдсан үнэт металлын үнийн дүн 1.2 дахин тус тус өссөн байна.



Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ этгээдүүд 26,244,623.4 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 45,524,568.6 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт эдлэл болон худалдан борлуулсан үнэт эдлэлийн үнийн дүн тус тус 1.5 дахин өссөн үзүүлэлт юм.



- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 51 хуулийн этгээд нь 62,637,971.4 мянган төгрөгийн нийт орлоготой, 53,021,981.8 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 9,615,989.6 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 0.9 дахин буурсан үзүүлэлт юм.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 98.7 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.